



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А951

Улаанбаатар хот

「 Стратегийн команд штабын сургуулийн  
бэлтгэл ажлыг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Стратегийн команд штабын дадлага сургууль зохион байгуулах тухай” А/194 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх стратегийн команд штабын дадлага сургуулийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор бэлтгэл ажлыг хангаж сургалтыг зохион байгуулахыг Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах)-д үүрэг болгосугай.

2.Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.

3.Сургалт, бэлтгэлийн үйл ажиллагаанд шаардагдах 1,035,000 (нэг сая гучин таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2023 оны 03 сарын 11-ны өдрийн А.С. дугаар  
захирамжийн хавсралт



СУРГАЛТ БЭЛТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төг)	Шаардагдах хэмжээ	Бүгд
1	Багшийн хөлс	цаг	280,000	2	560,000
2	Энгэрийн камер	ш	400,000	1	400,000
3	Хоолны зардал	ш	15,000	5	75,000
Нийт дүн					1,035,000